



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/350

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Суурьшлын бүсийн цахилгаан хангамж (Хишиг-Өндөр сум)”-ийн ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Бошголсон” ХХК-тай 166,846,224 (нэг зуун жаран зургаан сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун хорин дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Бошголсон” ХХК-ийн захирал (М.Цэрэндорж)-д даалгасугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
05 дугаар сарын 08-ны ний өдрийн  
А/350 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	2 897 139	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	2 897 139	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	1 448 570	Ү.Бямбасүрэн
4	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 90 хоног	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн